

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ КОМПАНИУДАД

Тодруулгад хариу хүргүүлэх нь:

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр урилга илгээсэн ЭАРХХК/20240101250 тоот дугаартай “Уул-өрөмдлөг, Баримтлуулалт, Сорьцлолт /Хүрэн цав/-ын ажил” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой оролцогчоос ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд :

№	Тодруулга	Хариу
1	<p>1. Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.10-т заасны дагуу захиалагч хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заах үүрэгтэй. Захиалагч нь 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-д нийтэлсэн тендер шалгаруулалтын зарлал (цахим)-ын 4-т “хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрнө” гэж; тендер шалгаруулалтын баримт бичигт хавсаргасан тендер шалгаруулалтын зарлал (бичгэн)-ын 4-т “хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөхгүй” гэж тус тус заасан нь төөрөгдөл үүсгээд байна. Иймд хувилбарт санал хүргүүлэхийг зөвшөөрсөн эсэхэд тодруулга хүсэж байна.</p>	<p>4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”</p>
2	<p>2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 19.2-ийн 1.6-д “Геологич инженерүүдийн 2-оос доошгүй нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх шаардлагатай. Хэрэв үндсэн ажилтан байгаа тохиолдолд НДШ-ийг сүүлийн 3 сар тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгж тасралтгүй төлсөн байна” гэж заасан. Тус хэсэгт “хэрэв үндсэн ажилтан байгаа тохиолдолд” гэсэн нь геологич инженер заавал үндсэн ажилтан байх шаардлагагүй, энэ тохиолдолд тэдгээрийн НДШ-ийг 3 сар төлсөн байхыг шаардахгүй мэтээр ойлголт төрүүлж байна. Улмаар геологич инженерүүдийн НДШ-ийг 3 сар төлсөн байх шаардлагатай эсэхийг тодруулж байгаад хариулт өгнө үү.</p>	<p>1.6. Хүснэгтэд заасан Төслийн удирдагч, Ахлах геологич гэсэн 2 ажилтан нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх шаардлагатай. Мөн Геологич инженерүүдийн 2-оос доошгүй нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байх шаардлагатай. Бусад инженер техникийн ажилчид нь гэрээт байж болно. Хэрэв үндсэн ажилтан байгаа тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгж тасралтгүй төлсөн байна. Нийгмийн даатгалын байгууллагын НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй, Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр шалгана. Гэрээт ажилтан байгаа тохиолдолд тухайн төсөлд зориулсан хөлсөөр ажиллах гэрээ байгуулан баталгаажуулж, хуулбарыг ирүүлэх.</p>

3	<p>3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 19.1 дүгээр зүйлийн 2-т заасан хүснэгтийн 2-т тендерт оролцогч өөрийн эзэмшлийн экскаватортой байхыг шаардсан. Харин 19.2 дүгээр зүйлийн 2-ийн 2.3-т “Хүснэгтэд заасан ажил гүйцэтгэхэд шаардлагатай дээж зөөх машин (кемп дотор) нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна. Өрмийн машины 50 хувиас доошгүй нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна. Бусад үндсэн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, машин механизмууд нь түрээсийн байж болно” гэж зааснаас экскаватор нь түрээснийх байж болохоор ойлгогдож байна. Иймд уг асуудалд тодруулга авах шаардлага үүссэн болно.</p>	№	Машин механизмын нэр	Тоо	Өөрийн эзэмшлийн эсэх
		2	Экскаватор (0.8-1 м³ шанагатай дугуйт)	1	Өөрийн эзэмшлийнх болон түрээсийн байна

2.3. Дээрх хүснэгтэд заасан ажил гүйцэтгэхэд шаардлагатай Дээж зөөх машин (кемп дотор) нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна. Өрмийн машины 50 хувиас доошгүй нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна. Бусад үндсэн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, машин механизмууд нь түрээсийн байж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО